

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ
ЗОРИЛГООР АРИЛЖААНЫ БАНКААР
ДАМЖУУЛАН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ
ТӨСЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ДЭД
КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

Нэг : Нийтлэг үндэслэл

1.1. Жижиг, дунд үйлдвэрийг санхүүгийн талаар дэмжих арга хэмжээг зохион байгуулах, арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах дэд комисс /цаашид “дэд комисс” гэх/ -ын үйл ажиллагаатай холбогдон гарах харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Хөнгөлөлттэй зээлийг Засгийн газрын тусгай сан болох Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан /цаашид “Сан” гэх/ -гийн хөрөнгөөс олгох ба энэхүү зээл нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд ажлын байр бий болгох, үйлдвэрлэлийг өргөтгөх боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

1.3. “Төсөл сонгон шалгаруулах дэд комисс”-ыг байгуулж аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллуулна.

1.4. Орон нутгийн дэд комисс нь дарга, дэд дарга, нарийн бичиг, гишүүдээс бүрдсэн 9 хүний, нийслэлийн дэд комисс нь орон тооны бус дарга, дэд дарга, нарийн бичиг, гишүүдээс бүрдсэн 11-13 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус байна.

1.5. Аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд комиссын Даргаар аймгийн Засаг дарга, Дэд даргаар ХХААЖДҮГазрын дарга, Нарийн бичгээр ХХААЖДҮГазрын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн байх ба гишүүдээр Оролцогч банкны төлөөлөл, Төрийн бус байгууллагын төлөөллийг оруулна.

1.6. Аймгийн Засаг дарга нь дэд комиссын дарга байх ба өөрийн шийдвэрээр эрхээ шилжүүлж болно.

1.7. Нийслэлийн төсөл сонгон шалгаруулах дэд комиссын Даргаар Үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан орлогч дарга, Дэд даргаар Үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, Нарийн бичгээр Үйлдвэрлэлийн хэлтсийн Жижиг, дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн байх ба гишүүдээр Оролцогч банкуудын төлөөлөл, төрийн бус байгууллагын төлөөллийг хамруулна.

1.8. Гишүүд нь төсөл сонгон шалгаруулах дэд комиссын хуралдаанд 1 саналын таслах эрхтэйгээр оролцож шийдвэр гаргана.

1.9. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгох банкыг Жижиг дунд үйлдвэрийн газар, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн саналыг үндэслэн ХХААХҮ-ийн сайд сонгон, гэрээ байгуулна.

1.10. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд банкаар дамжуулан зээл олгуулахаар Сангаас сонгосон банкны салбарт тусгай данс нээж, гэрээнд оролцогч талууд

гэрээнд тохиролцсон хэмжээний хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлж **ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН САН** /цаашид “сан” гэх/ бүрдүүлнэ.

1.11. Дээрх сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

1.11.1. Улсын төсвөөс Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд тусгагдсан хөрөнгө

1.11.2. Аймаг, нийслэлийн орон нутгийн төсвөөс гаргах хөрөнгө

1.11.3. Арилжааны банкнаас гаргах хөрөнгө

1.11.4. Санд зээлийн эргэн төлөлтөөс бүрдсэн хөрөнгө

Хоёр. Төсөл хүлээн авах

2.1. Дэд комисс хуралдаж хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт хүссэн төслүүдийг хүлээн авах хугацааг тохирч хэвлэл мэдээллээр олон нийтэд нээлттэй мэдэгдэнэ.

2.2. Төслийг хэвлэл, мэдээллээр зарласнаас хойш орон нутагт ХХААЖДҮГазрын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн, Нийслэлд Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн төслийг хүлээн авна.

2.3. Иргэнээс ирсэн төслийг харъяалалын дагуу, хуулийн этгээдийн төслийг тухайн төслийг хэрэгжүүлэх орон нутагт нь хүлээн авна.

2.4. Төсөл хүлээн авагч нь энэхүү журмын 3.2, 3.3-т дурьдсан шаардлагыг хангасан төслийг хүлээж авна:

2.5. Иргэн, хуулийн этгээд нь зээл хүссэн материалыг биеээр болон шуудангаар ирүүлнэ. Асуудал хариуцсан мэргэжилтэн шуудангаар ирсэн төсөлтэй танилцаж шаардлага хангаагүй төсөлд ажлын 10 хоногийн дотор хаягийн дагуу болон утсаар хариу өгнө.

2.6. Энэхүү журмын 2.2-т заасан мэргэжилтэн ирсэн төслийн материалын бүрдэлтэд дүн шинжилгээ хийж, шаардлага хангаагүй төслүүдийг хүлээн авахгүй байх ба бүрдэлт гүйцсэн материалыг бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтэнээр дамжуулан бүртгэж авна.

2.7. ЖДҮ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн хүлээн авсан материалыг төслийн нэгдсэн бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ.

2.8. Төсөл хүлээн авах шаардлага хангасан төслүүдэд зээлийн шинжилгээ, судалгаа хийж төсөл сонгон шалгаруулах дэд комиссын хуралдаанд оруулахаар /хавсралт – 1/-ийн дагуу бэлтгэнэ.

2.9. Төслүүдийн талаар боловсруулсан танилцуулга, мэдээллийг дэд комиссын хурал хуралдахаас ажлын 3 хоногийн өмнө комиссын гишүүдэд хүргүүлнэ.

Гурав. Төсөл сонгон шалгаруулах дэд комиссын үйл ажиллагаа

3.1. Дэд комисс нь жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр орж ирсэн төслүүдийн материалтай танилцан хэлэлцэж төсөлд санхүүжилт олгох, эс олгох талаар шийдвэрийг олонхийн саналаар гаргана.

3.2. Дараах шаардлагыг хангасан төслийг сонгон шалгаруулна.

3.2.1. “Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан байх;

3.2.2. Тухайн бизнесийг нэг жилээс доошгүй хугацаанд эрхэлсэн, зохих хэмжээний туршлагатай, зах зээлд тодорхой байр суурь эзэлсэн байх;

3.2.3. Татварын болон зээлийн хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх;

3.2.4. Хуулиар хориглоогүй барьцаа, батлан даалттай байх ба зээлийн барьцаа нь хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, бусдын өмчлөлд шилжүүлж болох эд хөрөнгийн эрх байна;

3.2.5. Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа явуулахад шаардагдах мэргэжлийн боловсон хүчин, ажлын байрны нөхцөлийг бүрдүүлсэн байх;

3.2.6. Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэх техникийн нөхцөл, байгаль орчны болон үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа явуулахад шаардлагатай холбогдох бусад зөвшөөрлийг авсан байх;

3.2.7. Бүтээгдэхүүн борлуулах гэрээ хийсэн, захиалгатай байх, боломжгүй тохиолдолд эрэлт хэрэгцээ, зах зээлийн багтаамжийг судалж тооцсон байх;

3.2.8. Тоног төхөөрөмж, техник технологийг шинэчлэхдээ дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн байх

3.2.9. Ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлсэн байх

3.3. Сангийн нийт хөрөнгийн 10-оос доошгүй хувийг шинээр бизнес эрхлэгчдэд зориулж, тэдний боловсруулсан төслийн хэрэгжих үндэслэлийг харгалзан үзэж зээл олгож болно. Доорхи шалгуур үзүүлэлтийг хангасан шинээр бизнес эрхлэгчдэд зээл олгоно. Үүнд:

3.3.1. Хэрэгжүүлэх төслийн санхүүжилтийн 30-иас доошгүй хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх чадвартай байх;

3.3.2. Төслийн үр дүнд бий болох бүтээгдэхүүн үйлчилгээ нь цаашид хөгжих боломжтой, шинэлэг байх;

3.3.3. Татварын болон зээлийн хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх;

3.3.4. Хуулиар хориглоогүй барьцаа, батлан даалттай байх ба зээлийн барьцаа нь хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, бусдын өмчлөлд шилжүүлж болох эд хөрөнгийн эрх байна;

3.3.5. Шинээр бизнес эрхлэгч нь тухайн төслийн салбартаа мэргэшсэн, дадлага туршлагатай боловсон хүчинтэй эсвэл бэлдэж байх;

3.3.6. Бүтээгдэхүүн борлуулах гэрээ хийсэн, захиалга авсан байх, боломжгүй тохиолдолд эрэлт хэрэгцээг тооцоолсон байх;

3.3.7. Тухайн хэрэгжүүлэх төслийн хүрээнд шаардлагатай тусгай зөвшөөрөл, техникийн нөхцлийг эрх бүхий байгууллагаас авсан байх;

3.3.8. Санхүүжүүлэх бизнес нь тогтмол мөнгөн орлоготой байх;

3.3.9. Тухайн бүтээгдэхүүний түүхий эдийн зах зээлийн судалгаа, үнийн түвшин, хэтийн төлвийн талаарх мэдээлэлтэй байх;

3.3.10. Үйлдвэрлэх бүтээгдэхүүний зах зээлийн хэрэгцээ, шаардлага, зах зээлийн цаашдын хандлагыг тодорхойлсон байх;

3.3.11. Дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн байх;

3.3.12. Орон нутгийн онцлогийг харгалзан нутгийн түүхий эдийн нөөцөд түшиглэсэн, үр ашигтай байх;

3.3.13. Ажлын байрыг хадгалсан, нэмэгдүүлсэн байх;

3.3.14. Зах зээлийн судалгаа, газар зүйн байрлалыг тусгасан байх;
/Зэргэлдээ аймаг, сумын хэрэгцээг судалсан байх/

3.4. Тухайн төслийн хамрах хүрээ, үр ашиг, санхүү, төлбөрийн чадварын байдлаас шалтгаалж нэг зээлдэгчид нийслэлд 100 хүртэл сая төгрөг, хөдөө орон нутагт 50 хүртэл сая төгрөгийг 3 хүртэл жилийн хугацаатай олгохоор шийдвэрлэнэ.

3.5. Дэд комиссоос дэмжигдсэн төслүүдийг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор дамжуулан зээлдүүлэх банкинд шилжүүлэх ба дэмжигдээгүй төслийн хариуг зээл хүсэгчдэд албан бичгээр мэдэгдэнэ. Албан бичигт төсөл шалгараагүй шалтгаан, үндэслэлийг тодорхой дурдана.

3.6. Гэрээ байгуулсан арилжааны банк нь ажлын 14 хоногт багтаан банкинд мөрдөгдөж буй журмын дагуу судлан шийдвэрлэж, орон нутгийн дэд комисст эргүүлэн мэдэгдэнэ.

3.7. Дэд комисс нь зээл хүссэн иргэн, хуулийн этгээдээс ирсэн төслийн тооноос хамааруулан хуралдааныг тухай бүр зохион байгуулна.

3.8. Аймаг, нийслэлийн төвд тухайн салбарын зах зээлийн багтаамжийг харгалзан нэг салбарт зээл авах зээлдэгчийн тоог дэд комисс тогтооно.

3.9. Хөнгөлөлттэй зээлийн явцын талаар цаг тухай бүр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд дэлгэрэнгүй мэдээллэж байна.

Дөрөв. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын эрх, үүрэг

4.1. Төсөл сонгон шалгаруулах дэд комиссын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад дэмжлэг үзүүлнэ.

4.2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээдээс төсөл боловсруулах явцад зөвлөгөө өгнө.

4.3. Тусгай зориулалтын санд орон нутгийн төсвөөс хөрөнгө олгож болох бөгөөд түүний хэмжээг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална

4.4. Зээл, зээлийн хүүг төлүүлэх үйл ажиллагаа удаашралтай байвал орон нутгийн төсөл шалгаруулах дэд комисс нь тухайн зээлдэгчид тулгарч буй бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлнэ.

4.5. Зээл авсан иргэн, хуулийн этгээдийг “Бизнесээ хөгжүүл” сургалтанд хамруулах үйл ажиллагааг дэмжих.

Тав. Батлан даалт гаргах

5.1 Төсөл сонгон шалгаруулах дэд комисс тусгай зориулалтын сангийн хөрөнгийн 10-аас доошгүй хувийг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу зээлийн батлан даалтын зориулалтаар ашиглана.

Зургаа. Хяналт тавих, тайлан гаргах

6.1 Дэд комиссын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, мониторинг хийх үүргийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар нь /цаашид “газар” гэх/, ХХААХҮЯамны Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газар, ЖДҮХСантай хамтарсан ажлын хэсэг гарч гүйцэтгэнэ.

6.2 Ажлын хэсэг нь хяналтыг жилд 2-оос доошгүй удаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих чиглэлээр улсын хэмжээнд олгогдсон зээлтэй газар дээр нь очиж танилцах байдлаар хийнэ.

6.3 Ажлын хэсгийн хяналт нь дэд комиссын үйл ажиллагаа, төсөл сонгон шалгаруулалт, төслийн хэрэгжилтэнд хяналт тавьж, мониторинг хийнэ. Ажлын хэсгээс гарсан тайланг Сайдад хагас жил тутам танилцуулна.

6.4 Тухайн орон нутгийн Дэд комиссын нарийн бичиг дэд комисст ирсэн төсөл, хуралдаанд оруулсан төсөл, шалгарсан төслийн талаарх мэдээг /хавсралт - 2/-ын дагуу/ долоо хоногийн 5 дахь өдөр бүр гаргаж ХХААХҮЯамны ЖДҮХСан, ЖДҮГазарт хүргүүлнэ. Дэлгэрэнгүй- мэдээг улирал бүр /хавсралт - 3/-ын дагуу-явцын мэдээний маягтыг хавсаргав ХХААХҮЯамны ЖДҮХСан, ЖДҮГазарт хүргүүлнэ.